



ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
РАШААНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2014 оны 01 сарын 30 өдөр

Дугаар 4/1

Рашаант сум

Г

Тэжээвэр амьтны талаар авах зарим  
арга хэмжээний тухай

7

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дахь хэсэг, Тэжээвэр амьтны тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сум орон нутгийн иргэд, хүүхдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэхийн тулд айл өрх бүрийг нохойгоо өглөөний 06 цагаас оройн 23 цаг хүртэл уятай байлгахыг даалгасугай.

2. Энэхүү захирамжийг сумын айл өрх бүрт танилцуулж, захирамжийн биелэлтийг хангаж ажиллахыг Цэнгэл багийн Засаг дарга (Б.Баянбаатар), Тээл багийн Засаг дарга (С.Далай), Талын-Ус багийн Засаг дарга (Б.Мөнхнасан), Энхтал багийн Засаг дарга (П.Мөнхтүвшин), Их-Ац багийн Засаг дарга (Д.Шинэбаяр) нарт даалгасугай.

3. Нохойгоо уяагүй айл өрхүүдэд хуулийн дагуу хариуцлага тооцож ажиллахыг хэсгийн төлөөлөгч (Н.Энхжил), хэсгийн цагдаа (Б.Наанбаатар) нарт үүрэг болгосугай.

4. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Т.Огтонцэцэг)-д үүрэг болгосугай.

  
Б.АЛТАНГЭРЭЛ